

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны 66 дугаар тэмдэглэлд:

"ХИҮ.ХЭЛЭЛЦСЭН нь: Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2013-2014 оны улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2013-2014 оны улсын хэлэлцээр байгуулагдсантай холбогдуулан уг хэлэлцээрийг үндэслэн хөдөлмөр, нийгмийн зөвшлийн салбарын болон аймаг, нийслэлийн хэлэлцээр байгуулах арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.

2. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2013-2014 оны улсын хэлэлцээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, явц, үр дүнг жил бүр Засгийн газарт танилцуулж байхыг Хөдөлмөрийн сайд Я.Санжмятавт үүрэг болгов.

3. Швейцарийн Холбооны Улсын Женев хотод болох Олон улсын хөдөлмөрийн ээлжит чуулганд Засгийн газар, үйлдвэрчний эвлэл болон ажил олгогч байгууллагаас тус бүр 3 төлөөлөгч оролцуулж, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхийг Сангийн сайд Ч.Улаан, Хөдөлмөрийн сайд Я.Санжмятав нарт даалгав." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР